



МОНГОЛ УЛСЫН  
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН  
ГИШҮҮНИЙ ЗӨВЛӨМЖ

2023 оны 01 дугаар сарын 09

№ 06/02

Улаанбаатар хот

ОЛИМП, НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН  
САЙД \_\_\_\_\_ ТАНАА

Комисст Биеийн тамир, спортын улсын хорооны Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн мэргэжилтэн \_\_\_\_\_ Төрийн захиргааны удирдлагын газрын хэвлэлийн ажилтан \_\_\_\_\_ нараас тус Хорооны дарга \_\_\_\_\_ Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчсөн тул холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шалган тогтоож, зөрчигдсэн эрхийг сэргээж, хуулийн дагуу зохих хариуцлагыг тооцож өгөхийг хүссэн гомдлыг ирүүлжээ.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 25 дугаар зүйл, 29 дүгээр зүйлийн 29.6.4 дэх хэсгийг үндэслэн гомдлын мөрөөр шалгалтын ажиллагаа явуулахад дараах нөхцөл байдал тогтоогдов.

1. Алба хаагчдын халдашгүй чөлөөтэй байх эрхэнд халдсан талаар:

Биеийн тамир, спортын Улсын хорооны Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн мэргэжилтэн \_\_\_\_\_ Төрийн захиргааны удирдлагын газрын хэвлэлийн ажилтан \_\_\_\_\_ нарыг тус Хорооны дарга \_\_\_\_\_ нь нийт ажилчдын шуурхай хурал дээр сууж байхад ажлын цагаар архи уусан нэрийдлээр гүтгэн, цагдаа дуудан баривчлуулан гавлуулж, цагдаагийн машинаар ачиж, Сүхбаатар дүүргийн Цагдаагийн газрын Нэгдүгээр хэлтэст хүргүүлсэн, энэ үйлдэл нь бид нарыг хамт олон болон спортын төв ордны гадна талд байсан иргэдийн нүдэн дээр гэмт хэрэг үйлдэн баривчлагдаж байгаагаар харагдаж ойлгогдсонд гомдолтой байна гэж дурджээ.

Комисс гомдол гаргагч болон Сүхбаатар дүүргийн Цагдаагийн газрын Нэгдүгээр хэлтсийн дуудлагаар үүрэг гүйцэтгэсэн алба хаагч нараас тайлбар авах, баримт, мэдээлэл гаргуулан авч шинжлэн үзэхэд 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 15 цаг 26 минутын үед 8819... дугаарын утсанаас Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороо Спортын төв ордны 3 давхарт "нэг согтуу хүн агсраад ажил хийлгэхгүй байна" гэх дуудлага, мэдээллийг өгсний дагуу 15 цаг 37 минутад Сүхбаатар дүүргийн Цагдаагийн газрын Нэгдүгээр хэлтсийн "Хүлэг-116" чиглэлийн машинт эргүүлийн алба хаагч нар шалгах ажиллагааг газар дээр нь хийж, Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ зөрчил гаргасан гэх \_\_\_\_\_ нарыг Хюндай 14-29 УАМ улсын дугаар бүхий албаны авто машинаар цагдаагийн газарт хүргэж ирсэн нь баримтаар тогтоогдож байна.

Дуудлагаар ажилласан Эргүүлийн офицер, цагдаагийн дэслэгч Б.Тогмоодорж, эргүүлийн цагдаа жолооч, цагдаагийн дэд ахлагч Б.Татенбек нар Комисст өгсөн тайлбартаа "...Биеийн тамир спортын улсын хорооны 3 давхарт дуудлага өгсөн хүний өрөөнд орж шалгахад согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн гэх нэг хүнийг тухайн

D:\2023 on\A4.month1.docx

150070009

байгууллагын ажилтан дагуулж орж ирсэн. Тэр хүнийг дагуулж өрөөнөөс хамт гарах үед нөгөө хүн нь өөрөө ирсэн. Тэр хоёрыг \_\_\_\_\_ нар болохыг тогтоож, 3 давхраас дагуулан авто машинд суулгаж, цагдаагийн хэлтэс рүү авч явсан. Хурлын үеэр болон олон нийтийн дундаас эдгээр хүмүүсийг авч яваагүй, гав тусгай хэрэгсэл хэрэглээгүй, тэдгээрийн нэр төр алдар хүндэд харшлахуйц сөрөг зүйл хэрэглээгүй, холбогдох хууль, журмын дагуу ажилласан болно. Тэгээд Цагдаагийн хэлтэс дээр очоод согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг зориулалтын тусгай хэрэгслээр (драйгер эвдэрсэн байсан) тогтоох боломжгүй байсан, харин тэдгээр 2 хүн нь гадаад байдлын хувьд согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн нь ил тод мэдэгдэж байсан бөгөөд агсам тавьж байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулж танхайрсан зүйл тогтоогдоогүй тул ажлын байран дээр согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн асуудлыг цагдаагийн байгууллага шалгахгүй, дотооддоо арга хэмжээ авч шийдвэрлэхийг зөвлөөд Ц.Батцайз гэх хүнд хүлээлгэн өгсөн” гэх тайлбарыг өгчээ.

Тус Хорооны хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн \_\_\_\_\_ “... \_\_\_\_\_ дарга дуудаж түүний өрөөнд ортол цагдаа дуудчих, нэр бүхий 4 алба хаагч цайны цагаар архи уусан, согтуу байна, баримтжуулах шаардлагатай учраас согтолтын зэрэг шалгах багажтай цагдаа дуудчих гэсэн би татгалзсан тул даргын туслах \_\_\_\_\_ утсаараа дуудлага өгсөн, .... Цагдаагийн хэлтэс рүү 2 алба хаагчийг цагдаагийн дуудлагын машинд авч явсан, миний бие хэлтсийн дарга О.Баттулгаас өгсөн үүргийн дагуу \_\_\_\_\_ нарын хамт хойноос нь очсон, цагдаа нар ажил дээрээ хэрүүл маргаан гаргаагүй, эрүүл хүмүүсийг тусгай хэрэгслээр (драйгер) шалгах хууль зүйн үндэслэлгүй гэх шалтгаанаар шалгахаас татгалзаж явуулсан, тухайн өдөр архидан согтуурсан ямар ч арга хэмжээ болоогүй..” гэж, даргын туслах Б.Баянбулаг хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн \_\_\_\_\_ цагдаад дуудлага өгөөч миний утас болохгүй байна гэсний дагуу Спортын төв ордонд согтуу хүн ажил хийлгэхгүй байна гэж надаар хэлүүлж цагдаад дуудлага өгүүлсэн ” гэх тайлбарыг тус тус өгчээ.

Тус хорооны дарга \_\_\_\_\_ Комисст өгсөн тайлбарт “...2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр миний бие өдрийн цайны цагаар ажилд ойрхон хоолны газарт орохоор хайж яваад “Туушин” зочид буудлын ард талд байрлах ресторанд ортол манай ажлын газрын ( \_\_\_\_\_ нар ширээ дүүрэн архи, пиво тавьсан байдалтай сууж байсан тул би тэдэн дээр очоод ажлын цагаар архины асуудал байж болохгүй гэж хэлээд гарч явсан” гэжээ.

Сүхбаатар дүүргийн Цагдаагийн газрын Нэгдүгээр хэлтсийн Шуурхай удирдлагын тасгийн дуудлагын №88198123 /РСНІ 12867180/ дугаар бүхий лавлагааны хуудаст 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн 15 цаг 37 минутад ирсэн дуудлагын дагуу \_\_\_\_\_ нарыг Цагдаагийн хэлтэс рүү авч явсан, тухайн өдрийн 16 цаг 14 минутад дуудлага мэдээллийг хааж шийдвэрлэсэн, Биеийн тамир, спортын Улсын хорооны 2022 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр “Ажлын цагаар согтууруулах төрлийн ундаа хэрэглэсэн тухай” сонсгох ажиллагаа явуулж, тэмдэглэл үйлдсэн баримтад мөн согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн талаар дурджээ.

Дээрх нөхцөл байдлаас дүгнэхэд \_\_\_\_\_ нарыг хурлын үеэр хамт олны дундаас дуудаж, улмаар цагдаагийн алба хаагч авч явсан (цагдаа хурал дээрээс авч яваагүй) гэх асуудал тогтоогдож байна. Харин ажлын байран дээр бусдын амгалан тайван байдлыг алдагдуулж танхайрсан, цагдаагийн алба хаагч гав, тусгай хэрэгсэл хэрэглэсэн гэх асуудлууд тогтоогдоогүй бөгөөд хорооны дарга Д.Жаргалсайханы өгсөн чиглэлийн дагуу \_\_\_\_\_ нар цагдаагийн байгууллагад зөрчлийн талаар худал дуудлага мэдээлэл өгсөн нь \_\_\_\_\_ і нарын эрх чөлөөг тодорхой хугацаанд хязгаарлах нөхцөлийг бүрдүүлсэн байна. Комисс нэр бүхий алба хаагчид

ажлын байран дээр согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн эсэхэд дүгнэлт хийгээгүй бөгөөд энэ нь хүний эрхийн асуудалд хамаарахгүйг дурдах нь зүйтэй.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 13-т “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч ... мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно”, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийн 1-т “Хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй. ... Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасаж болохгүй” гэжээ. Цагдаагийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт “Цагдаагийн алба хаагч нь гэмт хэрэг, зөрчил үйлдсэнд сэрдэгдэж байгаа хүний нэр, хаягийг тодруулах, гэмт хэрэг, зөрчилд холбогдуулан шалгах, албадан саатуулах үндэслэл байгаа эсэхийг тогтоох зорилгоор хүнийг 6 цаг хүртэл хугацаагаар түр саатуулж болно”, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсгийн 1-т “албан тушаалтанд хуульд нийцээгүй үүрэг, даалгавар өгөх, биелүүлэхийг шаардахыг хориглоно” гэж, Зөрчлийн тухай хуулийн 15.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Гэмт хэрэг, зөрчлийн талаар эрх бүхий байгууллагад хуурамч дуудлага, мэдээлэл өгсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж тус тус заажээ.

## 2. Байгууллагын хэмжээнд үзлэг, шалгалт зохион байгуулсан талаар:

Гомдол гаргагчид тус “Хорооны дарга [redacted] нь байгууллагын бүх алба хаагчдын өрөө, тасалгаа, шкаф, шүүгээ болон эд зүйлд хуулийн үндэслэлгүй прокурор, цагдаагийн байгууллагын зөвшөөрөлгүй, батлагдсан удирдамжгүйгээр зорилго, чиглэл нь тодорхойгүй, амаар өгсөн үүрэг чиглэлээр нэгжлэг хийж хүний эрхийг ноцтойгоор зөрчсөн, Биеийн тамир, спортын Улсын хорооны ажилтнууд дор бүрнээ эсэргүүцэж, удирдамж зөвшөөрлөө үзүүлэх, хувилж авахыг шаардахад шалгалт хийсэн алба хаагчид ямар нэгэн үзүүлэх зүйлгүй байсныг бүх л ажилтнууд гэрчилнэ” гэж гомдолд дурджээ.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311, 2018 оны 258, 2019 оны 33 дугаар тогтоол, 2017 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангах, Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 02 дугаар зөвлөмжийн дагуу тус Хорооны дарга Д.Жаргалсайхан 2022 оны 09 дүгээр сарын 14-ны өдөр “Ажлын байрны үзлэгийн удирдамж”-ийг баталж, ажлын хэсгийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан баримт бичиг, ажлын байранд үзлэг хийсэн 17 хуудас бүхий тэмдэглэлийг Комисс шалгалтын явцад гаргуулан авч нэг бүрчлэн хянасан. Үзлэгийг зохион байгуулах Ажлын хэсгийн ахлагч Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга [redacted] нь үзлэгийн зорилгыг [redacted]

[redacted] нарт удирдамжийг амаар танилцуулж үзлэг хийсэн нь тэмдэглэлд тусгагдсан бол бусад алба хаагчдад үзлэгийн удирдамж, зорилгыг амаар болон бичгээр танилцуулалгүйгээр явуулсан нь зарим алба хаагчдын дунд үл ойлголцол үүсгэжээ.

Байгууллагын хэмжээнд Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 311 дүгээр тогтоолоор батлагдсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 3.2 дугаар зүйлд “...бусад бүтцийн нэгжээс хараат бус нэгж, ажилтантай байна, ийм чиг үүрэг бүхий албан тушаалтан томилоогүй бол Захиргааны чиг үүрэг бүхий албан тушаалтнаар гүйцэтгүүлж болно” гэж заажээ.

Биеийн тамир, спортын Улсын хорооны даргын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/118 дугаар тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 10 дугаар

зүйлийн 10.3-т “Энэхүү журмын биелэлтийг нэгжийн дарга нар зохион байгуулж, хэрэгжилтэд нь Төрийн захиргааны асуудал хариуцсан нэгж хяналт тавина” гэж заажээ. Харин дотоод хяналт шалгалт зохион байгуулах талаар дээрх журамд нарийвчлан тусгаагүй боловч 7.11 дүгээр зүйлийн холбогдох хэсгүүдэд согтууруулах ундааны зүйл хэрэглэх, галт зэвсэг, хутга мэс, тэсэрч дэлбэрэх бодис оруулах, хадгалах хэрэглэх, ажлын байран дахь бүх хэлбэрийн дарамт шахалт, ялгавартай хандах аливаа хууль зөрчсөн үйлдэл гаргахыг хориглосон байна.

Иймд байгууллагын аюулгүй байдал, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сахилга хариуцлагыг сайжруулах зорилгоор байгууллагын даргын баталсан удирдамжийн дагуу нийт албан хаагчдын дунд нэг удаа явуулсан Ажлын байрны үзлэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 13-т заасан “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй...”, Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална”, мөн Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийн 1-т заасан “Хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй. ... Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасаж болохгүй” гэж тус тус заасныг зөрчсөн гэж үзэх боломжгүй.

Учир нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийг тайлбарлах тухай НҮБ-ын Хүний эрхийн хорооны 35 дугаар ерөнхий тайлбарт “Хүний чөлөөтэй байх эрх нь бүх нөхцөл байдалд хамаарах ерөнхий эрх чөлөө биш, харин хүнийг нийгмээс тусгаарлаж, хорихоос ангид байлгах тухай ойлголт” юм. Харин хувийн нууц гэдгийг Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4.1.11, 4.1.12 дахь хэсэгт зааснаар ойлгоно. Орон байрны халдашгүй байдлын тухайд албан өрөө нь нийтийн өмчид хамаардаг хэдий ч албаны үйл ажиллагаа явуулах орчин нөхцөл нь хүний хувийн орон зайд хэт халдахаас хамгаалагдсан байх ёстой. Тухайлбал, хүний чөлөөтэй зорчин явах эрхийг хязгаарласан, хувийн мэдээллийг олж авах, чөлөөт байдалд сөрөг нөлөө үзүүлж болохуйц газарт дууны, дүрсний, дуу-дүрсний хяналтын камер байршуулсан, хувь хүнийг мөрдөн мөшгөхөд чиглэгдсэн үзлэг, нэгжлэгийг нууцаар явуулсан, ажлын байранд бусад хүнээр хяналт тогтоолгосон гэх мэт хувь хүнд таагүй мэдрэмж, хохирол учруулахуйц үйлдлийг хамааруулна.

Тиймээс шалгалтын явцад хүний хувийн нууц, орон байрны халдашгүй байдлыг хөндсөн үйл баримт тогтоогдоогүй. Хэрэв дээр дурдсан хувийн орон зай болон орон байрны халдашгүй байдлыг хөндсөн баримт шинээр ирүүлсэн тохиолдолд Комисс дээрх дүгнэлтээ эргэн харах боломжтой.

### 3. Хөдөлмөрлөх эрхийн хэрэгжилтэд хяналт, шалгалтын хийсэн талаар:

Тус хорооны даргын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/118 дугаар тушаалаар баталсан байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-д 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж буй Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 6, 7 дугаар зүйл болон Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4.1 дэх заалт, мөн зүйлийн 11.7 дахь хэсэгт заасан ажил олгогчийн үүргийг нарийвчлан тусгаагүй, Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.2 дахь хэсэгт заасны дагуу байгууллагын “Дотоод журам”-ыг ажилтнуудад танилцуулж, харагдахуйц газар байршуулах үүргээ хэрэгжүүлээгүй, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4.2, 11.5.1 дэх заалтын дагуу сургалт, давтан сургалтын хөтөлбөр боловсруулаагүй, энэ чиглэлээр сургалт зохион байгуулаагүй байна.

Бүтцийн нэгжийн хувьд Хорооны дарга, газрын дарга 2, хэлтсийн дарга 6, нийтдээ 73 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулах ёстойгоос 2022 оны 11 дүгээр сарын 10-ний байдлаар 44 албан хаагч, ажилтан ажиллаж байгаа нь байгууллагын хэвийн үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй байдлыг үүсгэж, албан хаагчдын ажлын ачаалал нэмэгдэх, илүү цагаар ажиллах, ажлын бүтээмж буурах нөхцөлийг бүрдүүлжээ.

Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хууль, тогтоомж болон Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 258 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны сахилга, хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” журмын 1.4 дэх заалт “...төрийн жинхэнэ албан тушаалд сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллага болон төрийн холбогдох байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ алба хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэжлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилох замаар төрийн мэргэшсэн албыг бэхжүүлэх” гэсэн зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй байна. Тухайлбал, Төрийн албаны зөвлөлийн даргын 2022 оны 77 дугаар тушаалаар байгуулагдсан сонгон шалгаруулалтын комисс Биеийн тамир, спортын улсын хорооны Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн даргын сул орон тооны сонгон шалгаруулалтыг 04 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулж, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 06 дугаар арын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж, Б.Нямсүрэнг томилуулахаар нэр дэвшүүлсэн тогтоолыг хүргүүлсэн боловч 2022 оны 11 дүгээр сарын 23-ний байдлаар томилгоо хийгдээгүй байсан. Мөн тус Хороонд ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байсан Д.Ариунсанааг “Цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон, тэтгэвэр авдаг” гэсэн хуульд заагаагүй үндэслэлээр албан тушаалаас нь чөлөөлсөн байна.

Тус хорооны удирдлагад 2022 оны 11 дүгээр сарын 23-ны байдлаар нийтдээ 120 өргөдөл, хүсэлт ирснээс (ажилтан, албан хаагчдаас 68, иргэдээс 52) 117 буюу 97 хувийг нь бүрэн шийдвэрлэж, 3 өргөдлийн үлдэгдэлтэй байсан. Үүнээс үзэхэд ажилтан, албан хаагчдын санал хүсэлтийг цаг тухай бүр хүлээн авч шийдвэрлэж тэдэнд хариу өгч ажилласан байна. Ирүүлсэн өргөдөл, хүсэлтийг ангилан үзвэл, ажлаас чөлөөлөгдөх 10, цалинтай чөлөө хүсэх 6, өндөр настны тэтгэвэрт гарах 4, хүүхэд асрах чөлөө хүсэх 2, жирэмсний амралт авах 2, ээлжийн амралт авах тухай 1, төрийн алба хаасны нэмэгдэл авах, шатлал ахиулах 12, сургалтын төлбөрийн дэмжлэг хүсэх 4, тендерийн хорооноос гарах 1, төрийн албанд жинхлэн томилогдох тухай 3, сургалтад хамрагдах 4, цахимаар ажиллах 1, хавсран ажиллахаас чөлөөлөх тухай 1, шилжин ажиллах 3, тайлбар хүргүүлэх 3, бусад 10 байна.

Байгууллагын ёс зүйн хороо 7 хүний бүрэлдэхүүнтэй бөгөөд 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр 01 дүгээр хуралдааныг зохион байгуулж 3 албан хаагчийн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн нь энэ оны анхны хуралдаан байжээ. Эндээс үзэхэд улирал тутам байгууллагын сахилга, ёс зүйн зөвлөгөөнийг хийж хэвшээгүй, ёс зүйн хорооны үйл ажиллагаа тогтмолжоогүй, албан хэрэг хөтлөлтийн бүрдүүлбэр хангалтгүй байгаа нь ажлын байрны дарамт хүчирхийлэл үйлдэгдэх, хөдөлмөрлөх эрхийн аливаа зөрчил гарч болзошгүй орчинг бүрдүүлжээ. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 6 дугаар зүйлийн 6.2 дугаар хэсэгт “...төрийн албан хаагчдын саналыг үндэслэн томилох эрх бүхий албан тушаалтан Ёс зүйн хорооны гишүүдийг гурван жилийн хугацаагаар томилно” гэсэн заалтын хэрэгжилт хангалтгүй байлаа.

Хөдөлмөрийн харилцаан дахь дарамт, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, үл тэвчих, орчныг бүрдүүлэх, сургалт соён гэгээрүүлэх чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээ төлөвлөж,

хэрэгжүүлээгүй, 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/220 дугаар тушаалаар байгуулсан Жендерийн хороо нь бодитой ажил хийгээгүй нь хөдөлмөрийн тухай хуулийн 6,7 дугаар зүйл, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиар хүлээсэн үүргийн биелэлт байгууллагын хэмжээнд хангалтгүй байгааг харуулж байна. Комисс шалгалтын явцад тус Хорооны 19 алба хаагчтай ярилцлага хийхэд "...манай байгууллагын албан хаагч нарын дунд үл ойлголцол гарах болсон", үзэл бодлын хувьд зөрчилдөөнтэй", "...Байгууллагын нууц гэж байхаа больсон", "...Хамт олны уур амьсгал өөрчлөгдсөн", "...даргын ажлын арга барил хоцрогдсон", "...удирдлагын баг ажлаа ил тод нээлттэй ярихаа больж бие биеэсээ жийрхсэн, айсан байдалтай болсон", "...Энэ байгууллагад ажлын байрны дарамт байдаг, ажилтнууд бүгд мэднэ", "...удирдлагууд юм л бол камер шүүдэг л байгууллага болсон", "Ээлжийн амралттай, өвчтэй, чөлөөтэй байх хугацаанд дуудан ажиллуулдаг" гэх асуудлыг нийтлэг байдлаар илэрхийлж байсан нь анхаарал татаж байлаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 4-т "...хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах...", Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 7 дугаар зүйлд "Энэхүү пактад оролцогч улсууд хүн бүр хөдөлмөрийн шударга, таатай нөхцөлөөр хангагдах эрхийг хүлээн зөвшөөрнө" гэж Хөдөлмөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлд Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхахыг хориглох, 7 дугаар зүйлд Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглох зохицуулалтыг тус тус хуульчилсан.

Иймд хяналт шалгалтаар тогтоогдсон нөхцөл байдлыг үндэслэн тус Хорооны албан хаагчдын хөдөлмөрийн таатай нөхцөлөөр хангагдах, ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхалт болон дарамт, хүчирхийллээс ангид байх эрхийг хангах зорилгоор Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэгт заасан Комиссын гишүүний бүрэн эрхийн хүрээнд дараах Зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Бусдаар цагдаагийн байгууллагад худал дуудлага мэдээлэл өгүүлж, нарын эрх чөлөөг тодорхой хугацаанд хязгаарлахад хүргэсэн Биеийн тамир, спортын Улсын хорооны дарга Д.Жаргалсайханд нэр бүхий албан хаагчдаас уучлалт гуйх үүргийг даалгах;
2. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.3, 7.4 дэх хэсэг, Жендерийн эрх, тэгш байдлыг хангах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4.1, мөн зүйлийн 11.7 дахь хэсэгт заасан ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, гарсан гомдлыг шийдвэрлэх журмыг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд заалт бүрээр нарийвчлан тусгах, энэ талаарх гомдлыг хүлээн авах байгууллага, албан тушаалтны нэр, хаяг, харилцах утас, цахим шуудангийн хаягийг ажил олгогч нийт ажилтанд харагдахуйц газар байршуулах, зөрчил гаргагчид хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлж хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах;
3. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийн 6.1-д заасны дагуу тус хорооны дэргэд ёс зүйн зөвлөлийг тасралтгүй, үр дүнтэй ажилуулах;
4. Ёс зүйн хорооны даргыг нийт албан хаагчдын саналыг үндэслэн сонгох, улирал бүр байгууллагын сахилга ёс зүйн зөвлөгөөнийг зохион байгуулж, тайлагнаж хэвших;
5. Албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр ажиллаж байгаа албан хаагчдыг албан тушаалын сул орон тоонд жинхлэн томилох, албан тушаалын сул орон тоог

- хууль тогтоомжийн дагуу нөхөх арга хэмжээг шуурхай авч алба хаагчдын хөдөлмөрийн таатай нөхцөлийг бүрдүүлэн ажиллах;
6. Хууль тогтоомжид заасан цалин хөлсний нэмэгдэлгүйгээр ажил хавсран гүйцэтгүүлэх явдлыг таслан зогсоох;
  7. "Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд ялгаварлан гадуурхах", "Ажил эрхлэлт, хөдөлмөрийн харилцаанд дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх", "Хүний эрхэд суурилсан хандлага"-ын талаарх алба хаагчдын мэдлэг хандлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалтын төлөвлөгөө гаргах, тогтмол хугацаанд сургалт зохион байгуулж хэвших, энэ сургалтанд байгууллагын удирдах албан тушаалтнууд заавал хамрагддаг байх;
  8. Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу мэдээлэл хариуцагчтай холбоотой зохицуулалтыг нэг мөр дагаж мөрдөх, мөн зүйлийн 18.2.1 дэх хэсэгт заасны дагуу хуульд нийцүүлэн хувь хүний мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах журам баталж, мөрдүүлэх;
  9. Хүний эрхийн мэдлэг боловсрол олгох, хүний эрхэд суурилсан төрийн албыг төлөвшүүлэхэд чиглэсэн соён гэгээрүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж, нийт алба хаагчдын дунд тогтмол хугацаанд зохион байгуулж байх;
  10. Хорооны удирдлагаас албан хаагчдад хүргүүлж буй мэдээллийн ил тод байдлыг хангаж, Захиргааны үйл ажиллагаанд хуульд үндэслэх зарчмыг баримтлан үндэслэлтэй шийдвэр гаргаж хэвших, түүний хэрэгжилтэд тогтмол хяналт тавих;

Зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасан хугацаанд буюу 30 хоногийн дотор хариу ирүүлнэ үү.

ГИШҮҮН



Б.ЭНХБОЛД